

21. Аав аа, ичгүүрээсээ Камбожид болсон хүчингийн хэргийн талаар мэдээлдэггүй, хэн нэгэн гэр бүлээс минь өшөө авах болно гэж айдаг хүмүүсийн төлөө бид залбирч байна. Тэд зориг, тусламж, хамгаалалтыг олж, хүчтэй байх болтугай. (Дуу. 91: 2)

22. Бурхан минь ээ, сар бүр Либерид 10-15 охин аав, асран хамгаалагчдаа хүчирхийлүүлдэг. Тэднийг зогсоогооч Бурхан минь! (Дуу. 103: 6)

23. Төгс Хүчит Бурхан минь, Өмнөд Африкт хүчирхийлэл эрс нэмэгдсэн. Гэр бүлийн хүчирхийллийн ихэнх тохиолдол гэрт нь гардаг, та эдгээр хохирогчдыг хамгаалаач. (Ис. 32:18)

24. Нигүүлслийн Бурхан минь, эмэгтэйчүүд сэтгэлзүй, бие махбодийн хүчирхийлэлд маш ихээр өртдөг Хойд Киприйн салсан гэр бүлүүдэд амар амгалан, эвлэрлийг авчираач. "Найдвартай эмэгтэйчүүд" хөтөлбөрүүд тэдэнд итгэл найдвар, эдгэрэлтийг авчрах болтугай. (Ром 15:13)

25. Эзэн минь, Танзанидад гэртээ хүчиндүүлж, хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдийн зүрх сэтгэл, оюун санааг сэргээгээч. (Дуу. 17: 8-9)

26. Эцэг Бурхан минь, гэр бүлийн хүчирхийллийг Украинд ихэвчлэн нуудаг бөгөөд хохирогчдын ердөө 10% нь энэ тухай мэдээлдэг бөгөөд олон хүн үүнийг хувийн асуудал гэж үздэг. Эрх чөлөө, эдгэрэлт, шударга ёсыг энэ улсад Та авчираач!. (Марк 4:22)

27. Филиппинд хүчингийн болон гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд үгээ хэлж, хамгаалуулж, эдгэрч, шударга ёсыг олох болтугай. тэднийг хүчирхийлэгчид хүчирхийллээс татгалзаж, эмэгтэйчүүдийг хүндэлж сураасай гэж бид залбирч байна. (Ис. 1:16)

28. Эзэн минь ээ, асуудлыг зохицуулах цагдаатай улсууд байдагт баярлалаа. Эдгээр орнуудын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдэд тусламж хүсэхэд өөртөө итгэх итгэл, хүч чадлыг өгөөч. (Дуу. 46: 1)

29. Аав аа, үндэсний гамшиг, зөрчилдөөн, цагаачлалын улмаас түр орон сууцанд амьдарч буй эмэгтэйчүүдийг хүчирхийллээс хамгаалаач. (Ис. 41:10)


30. Бурхан минь, сургууль бол сурч боловсрох, өсч хөгжих аюулгүй газар байх ёстой. Эцэг эхчүүд, багш нар, удирдлагуудад сургуулийн дээрлэхэл, аливаа хүчирхийллийг тэвчихгүй байх мэргэн ухааныг өгөөч. (Дуу. 32: 7)

31. Эзэн минь, Та биднийг хайрладаг шиг биднийг үзэн яддаг, гомдоодог хүмүүсийг хайрлахад бидэнд туслаач. Та биднийг тулалдаанд оролцож байхад хүчтэй байхад минь бидэнд туслаач!. (Лук 6: 27-28)



**Найдвартай  
эмэгтэйчүүд**

Сар бүр гаргадаг "Найдвартай эмэгтэйчүүд" залбирлын хуанли 100 хэл дээр орчуулагдсан бөгөөд 65,000 гаруй хүн хамтдаа залбирч байна.



**2021. 10.**

**Хүчирхийлэл**

Хүчирхийлэл нь хүний амьдралын бүх зүйлд маш хүчтэй нөлөөлдөг. Хүчирхийлэлд өртсөн хүмүүст Бурханы хайр, эдгэрэл, өршөөлийг мэдрүүлэхийн төлөө залбирцгаая! Бурханы эдгээгч гар нь эмэгтэй хүнийг сэргээгээд зогсохгүй түүний гомдоосон, хүчирхийлсэн хүмүүсийг уучлах боломжийг олгодог. Бусдыг уучилснаар сэтгэлийн шарх бүрэн эдгэрдэг!

**TWR Korea 북방선교방송**

서울특별시 관악구 양녕로 15, 월드빌딩 6층  
전화 (02)886-5671 / 이메일 phkorea@twrk.or.kr

후원안내

국민은행 851-01-0003-724 북방선교방송

## Бүгдээрээ хамтдаа залбирцгаая!

1. Аав аа, тусгаарлалтаас үүдэлтэй стресс нь Япон эмэгтэйчүүдэд бие махбодь, оюун санаа, санхүүгийн болон бэлгийн хүчирхийлэл нэмэгдэхэд нөлөөлсөн. Эдгээр эмэгтэйчүүдийг энэхүү хүчирхийллээс гаргах, тусламж авах, таныг харанхуйд гэрэл болгон харах боломжийг олгооч. (Дуу. 31: 4)

2. Аав аа, Канад дахь 10 эмэгтэйчүүдийн 6 нь бие махбодийн болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн тухайгаа мэдээлж байна. Хүчирхийллээс айхгүйгээр амьдрахад нь туслах соёлын сэтгэлгээ, дадал зуршил, хууль тогтоомжид өөрчлөлт оруулаач гэж бид залбирч байна. (Ис. 41:10)

3. Эзэн минь, Энэтхэгт эмэгтэйчүүдийг үл хүндэтгэдэг, хүчирхийлдэг эрчүүдийн зүрх сэтгэл, оюун санааг өөрчилж өгөөч. Энэтхэг эмэгтэйчүүдийг нэр төртэй байлгаж, Бие мах бодийн хамгаалж, боловсрол эзэмшүүлж, Есүс Христ доторх жинхэнэ амар амгаланг олох боломжийг олгооч. (Дуу. 4: 8)

4. Төгс Хүчит Эзэн минь, Финляндын хууль тогтоомж өөрчлөгдөн, хүчирхийлэлд өртөгсдийн хоргодох газрууд илүү хүртээмжтэй болж байгаад талархаж байна. (Сур. 30: 5)

5. Өршөөлийн Бурхан минь, Кот -д'Ивуарын сургуулийн сурагчдыг багш нар нь хүчирхийлэхээс хамгаалаарай. Эмэгтэйчүүдийн бэлэг эрхтнийг зэрэмдэглэх ёс заншлыг халж, хохирогчдод зохих эмнэлгийн тусламж үзүүлээсэй гэж бид залбирч байна. (Дуу. 5:11)

6. Бурхан Эцэг минь ээ, Дани улсад өөрийгөө үнэлэх чадвараа алдсан, гэртээ хүчирхийллээс зугтаж чадахгүй байгаа Дани улсын эмэгтэйчүүдийг хараач! Тэдэнд итгэл найдварыг нь буцааж өгөөч. (Дуулал 68:19)

7. Аав аа, гэр бүл дэх хүчирхийллээс болж гэр бүлүүд салж, хүүхдүүд зугтаж, хойч үедээ энэ зан үйлийг давтах болсон Солонгосын гэр бүлийн харилцааг эдгэрэхын төлөө бид залбирч байна. (Дуу. 147: 3)

8. Эзэн минээ Португалд, залуучуудын 67% нь хүчирхийлэгчтэй болзож болно гэж үздэг. Жинхэнэ хайр гэж юу болохыг тэдэнд зааж, бие биенээ хүндэтгэж сурах болтугай. (1 Иохан 4: 10-11)

9. Стресс, ядуурал, тусгаарлалт, ажилгүйдэл нь Уругвайд эмэгтэйчүүдийн эсрэг бэлгийн болон биеийн хүчирхийлэл нэмэгдэхэд нөлөөлсөн. Эзэн минь, хүмүүст стрессээ тайлах эрүүл аргуудыг олоход нь тусалж, асуудлаа шийдвэрлэхэд нь туслаач. (Флп. 2: 2)

10. Бурхан минь, Зимбабвегийн охидыг хамаатан садныхан хэл ам болон хүчирхийллээс хамгаалаач!. Хүчирхийлэлд өртсөн үед гэр бүлийн гишүүдэд нь "гэр бүлийн нэр төрийг хамгаалах" гэж байна гээд чимээгүй өнгөрч байж болохгүйг ойлгуулаач, харин эдгээр хүүхдүүдийг хамгаалах, хайрлах, өөрийнхөө үнэ цэнийг үнэлэх ёстойг ухааруулаач (Сур. 18: 5).

11. Эзэн минь, шархалсан зүрхтэй Румынчууд бусдад хор хөнөөл учруулж байгааг нь зогсоогооч. Таны гайхамшигт хайр тэдний дотор орж, тэд бусдыг хайрлаж сурах болтугай. (Тит 2:12)

12. Эзэн минь, бид бүх төрлийн хүчирхийлэлд өртсөн Парагвай эмэгтэйчүүдийн төлөө залбирч байна. Таны ард түмэн хүчирхийллээс зугтаж, Таны Үгээр дамжуулан чөлөөлөгдөхөд нь туслах болтугай (Иохан 8:36).

13. Бид Эзэн минь, Польшид архинд донтсон эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн төлөө залбирч байна. Эхнэх нөхөрүүд Бие биенээ хүчирхийлэхгүй, хүүхдэдээ хайхрамжгүй хандахгүйн тулд тэдний сэтгэлийг эдгээгээч. (Сур. 20: 1)

14. Эзэн минь, тусгаарлалтын үед гэр бүлийн хүчирхийлэл улам бүр нэмэгдсээр байгаа тул бид Франц дахь эмэгтэйчүүд, хүүхдүүдийн төлөө залбирч байна. “Нөхрүүд ээ, эхнэрүүдээ хайрла, тэдэнд битгий хатуу хандаач”. (Кол. 3:19)

15. Бурхан минь, хүчирхийлэлд өртсөн Хойд Кавказын эмэгтэйчүүд болон гэр бүлийн харилцаанд итгэх итгэлээ алдсан орос эмэгтэйчүүдийн зүрх сэтгэлийг эдгээгээч! (Дуу. 72: 13-14).

16. Аав аа, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг тэвчдэг Этиопын соёлын гишүүдийн хандлага, зан заншлыг өөрчилөөч. Этиопдох эмэгтэйчүүдийн 19 хувь нь хамтрагчаасаа болж бие махбодидоо хор хөнөөл учруулж байгааг эдгээгээч!. Гэмтэл бэртэл авсан олон эмэгтэйчүүд заавал эмнэлгийн тусламж авах шаардлагатай болдог. (Дуулал 30: 2)

17. Эцэг минь, Шведэд тусгаарлагдмал байдал, эдийн засгийн боломж хязгаарлагдмал байгаа хүмүүстэй хамт байгаарай. Тэднийг хүчирхийлэлд хүргэж болзошгүй стрессээс хамгаалаач. (Дуу. 94:19)

18. Эзэн минь, Гренланд улсад архи, мансууруулах бодис, залуучуудын ажилгүйдэл зэрэг нийгмийн асуудалууд хүчирхийллийг ихэсгэх гэмт хэрэгт хувь нэмэр оруулж байна. Хүмүүс танд хандан залбирхын төлөө тэдэнд оюун санааны сэргэлтийг авчираач. (Езек. 11:19)

19. Төгс Хүчит Бурхан минь, Индонезийн цагдаа нар хүчирхийллийн тухай сонсоод хурдан хариу үйлдэл үзүүлж байгаад нь бид маш их баяртай байна. “ЭЗЭН, зовж шаналсан хүмүүсийн хүслийг та сонсдог” (Дуу. 10: 17-18).

20. Тэнгэрлэг Эцэг минь, бид Испанид гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн хүмүүсийг гэмшиж, амьдралаа өөрчлөх болтугай гэж гуйн залбирч байна (Дуу. 11: 5).